



# КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ТАЙЛАН 2018

# Агуулга



4	КОМПАНИЙН ТУХАЙ
8	КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА
16	АЖЛЫН БАЙР
20	ХАНГАН НИЙЛҮҮЛЭЛТ, ХУДАЛДАН АВАЛТ
22	БАЙГАЛЬ ОРЧИН
26	ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ
28	2018 ОНЫ АМЖИЛТУУД

## ЭРХЭМ ЗОРИЛГО

Бид орчин үеийн техник, технологийг мэргэшсэн боловсон хүчний ур чадвар, хүсэл тэмүүлэлтэй хослуулан Монгол Улсын хөгжил, эдийн засгийн өсөлтөнд хувь нэмрээ оруулна.

## АЛСЫН ХАРАА

Бид олон улсын зах зээл дээр нүүрс, нүүрсэн бүтээгдэхүүн борлуулах дэлхийн хэмжээний үйл ажиллагаатай үйлдвэрлэгч компани болно.

## ҮНЭТ ЗҮЙЛС

**Ажиллагсад, боловсон хүчин манай компанийн амин чухал зүйл гэж бид үздэг, иймд:**

Энержи Ресурс ХХК нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчинд нэн тэргүүнд анхаарна.

Энержи Ресурс ХХК нь ур чадвар, ажлын үр дүнг харгалзсан хөдөлмөр эрхлэлтийн адил тэгш боломжоор хангаж хариуцлагатай ажил олгогч байна.

**Орчин үеийн өндөр үр өгөөжтэй техник технологи нь Монгол Улсад хөгжил дэвшил авчирна гэдэгт бид итгэдэг, иймд:**

Энержи Ресурс ХХК нь сайн чанарын бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг дэлхийн түвшний нүүрсний уурхай байгуулж хөгжүүлнэ.

Энержи Ресурс ХХК нь Монгол Улсын нүүрс олборлолтын салбарт техникийн шинэ стандарт тогтоохыг зоринo.

**Бид байгаль орчны хариуцлагатай уурхайн үйл ажиллагаа явуулдаг, иймд:**

Энержи Ресурс ХХК-ийн уурхай, дагалдах инженерийн бүтцийг байгаль орчинд аль болохоор бага нөлөөлөл учруулахаар зохион байгуулна.

Энержи Ресурс ХХК нь шаардлагатай бүх байгаль орчны стандартуудыг мөрдөж, байгаль орчинд учирч болзошгүй нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийг авна.

**Бид нийгмийн хариуцлагатай уурхайн үйл ажиллагаа явуулдаг, иймд:**

Энержи Ресурс ХХК нь иргэд, засаг захиргааны байгууллага, харилцагч, нийлүүлэгчидтэй “сайн хөрш”-ийн харилцааг хөгжүүлнэ.

Энержи Ресурс ХХК нь иргэдэд чиглэсэн бодлого, хөтөлбөрүүдээр дамжуулан нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулна.

**Компанийн сайн засаглал нь Энержи Ресурс ХХК-ийг ажиллуулах, удирдах, хяналтыг хэрэгжүүлэх үзэл баримтлал гэж бид үздэг, иймд:**

Энержи Ресурс ХХК нь олон улсын шилдэг туршлагыг үйл ажиллагаандаа нэвтрүүлнэ.

Энержи Ресурс ХХК нь компанийн засаглалын соёлыг байгууллагынхаа хөгжлийн салшгүй хэсэг болгон мөрдөнө.

# Компанийн тухай



## ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Энержи Ресурс компани нь 2005 онд байгуулагдсан үндэсний хөрөнгө оруулалттай уул уурхайн компани бөгөөд Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дахь Ухаа худаг нүүрсний уурхайд үйл ажиллагаа явуулдаг. 2010 оны 10-р сард Монголын үндэсний компаниудаас анх удаа Хонконгийн хөрөнгийн биржид амжилттай IPO хийж, олон улсын хөрөнгийн зах зээлд хувьцаагаа гаргасан нээлттэй хувьцаат компани бөгөөд хувьцааны хяналтын багцыг үндэсний хөрөнгө оруулагчид эзэмшдэг.

Бид 2009 оноос Ухаа худагийн хөндийд томоохон бүтээн байгуулалтын ажлуудыг өрнүүлж эхэлсэн. Алслагдсан говь нутагт маш богино хугацаанд монгол инженер, техникийн ажилтнуудын хамтын хүчээр нүүрс баяжуулах үйлдвэр болон 18 мегаваттын цахилгаан станц, хатуу хучилттай авто зам, усан хангамжийн систем, 650 айлын орон сууцны хороолол, 700 хүүхдийн багтаамжтай сургууль, цэцэрлэг зэрэг дэд бүтцийн томоохон байгууламжуудыг барьж ашиглалтад оруулан, дэлхийн жишигт нийцсэн уул уурхайн цогцолборыг бий болгосон.

Өнгөрсөн арван жилийн хугацаанд компани нийт 1.2 их наяд орчим төгрөгийг уурхайн болон дагалдах дэд бүтцийн төслүүдийн хөрөнгө оруулалтанд зарцуулсан төдийгүй 1.1 их наяд төгрөгийг татвар, шимтгэл хэлбэрээр улсын төсөвт төвлөрүүлжээ.

Анх 2005 онд Монголын үндэсний компаниуд нэгдэж, Энержи Ресурс компанийг үүсгэн байгуулсан бөгөөд улмаар 2008 онд Ухаа худагийн хөндийд их бүтээн байгуулалтыг өрнүүлж эхэлсэн түүхтэй.

Өнгөрсөн 10 жилийн хугацаанд тус компаниас Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд оруулсан бодит хувь нэмрээс тоймлолов:


- **Татвар:** Татвар төлөлтөөр улсын хэмжээнд тогтмол "айрагдаж" ирсэн бөгөөд үйл ажиллагаагаа эхлүүлсэн цагаас хойш өнөөг хүртэлх хугацаанд улс, орон нутгийн төсөвт татвар, хураамж хэлбэрээр 1.1 их наяд төгрөгийг төвлөрүүлсэн;

## БАЙРШИЛ

- Өмнөговь аймгийн Цогтцэций сумын төвөөс 8 км
- Аймгийн нийслэл Даланзадгад хотоос зүүн тийш 90 км
- УБ хотоос өмнө зүгт 540 км

## УЛСЫН ТӨСӨВТ ОРУУЛСАН ТАТВАРЫН ДҮН /2016-2018/

Тэрбум төгрөг



- **Хөрөнгө оруулалт:** Уул уурхай, үйлдвэрлэл, усан болон цахилгаан эрчим хүчний хангамж, нийгмийн дэд бүтцийн цогц бүтээн байгуулалтын ажилд 1.2 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн;
- **Хамтын ажиллагаа:** Дотоодын 4,000 гаруй аж ахуйн нэгжтэй туслан гүйцэтгэгч, ханган нийлүүлэгч хэлбэрээр хамтран ажиллаж ирсэн.
- **Ажил олголт:** Үндэсний боловсон хүчний нөөц боломжид тулгуурласан бүтээн байгуулалт хийж, үйл ажиллагаа явуулснаар 4,000 гаруй иргэн шууд ба шууд бус ажлын байраар хангагдсаны 50 орчим хувийг Өмнөговь аймгийн иргэд бүрдүүлж ирсэн.

## 2018 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

Монголдоо анх удаа Олон улсын менежментийн нэгдсэн тогтолцоог (ISO 9001:2015, ISO 14001:2015, OHSAS 18001:2007) амжилттай нэвтрүүлээ.

Цогтцэций сумын “Мөрөөдөл” цогцолбор болон Т.Борын нэрэмжит ЕБС-д Орон нутгийн боловсролыг дэмжих цогц хөтөлбөрийг дахин эхлүүлээ. Энэ хүрээнд менежментийн болон математикийн зөвлөх, шаардлагатай багш нар авч ажиллуулах, англи хэлний болон математикийн онлайн хөтөлбөр хэрэгжүүлэх, багш нарыг үр дүнгийн урамшуулалд хамруулах зэргээр орон нутгийн боловсролын чанар, хүртээмжийг сайжруулахаар зорьж байна.

Цогтцэций сумын оюутан залууст амралтаараа ажил эрхлэх, нэмэлт орлого олох боломж олгох, улмаар хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөх чадварыг нь нэмэгдүүлэх зорилгоор “Амралтаараа ажиллая” хөтөлбөрийг хэрэгжүүлээ. Энэ хүрээнд 22 оюутныг мэргэжлийн чиглэлийн дагуу дадлагажуулж ажиллуулсан.

Лантуун дохио ТББ-аас хэрэгжүүлж буй “Ид шидийн орон II” хүүхэд хамгааллын төсөлд шаардлагатай санхүүжилтийн 50 хувь буюу нийт 740 сая төгрөгийг хандивлалаа. Уг санхүүжилтийн хүрээнд Баянзүрх дүүрэг, Улиастайн эцэст 4,200 кв бүхий “Ид шидийн орон II” хүүхэд хамгааллын цогцолбор төв баригдаж байна.

“Эрүүл үрс, гэрэлт ирээдүй” ТББ-тай хамтран говийн бүсийн аймгуудын хүүхдийн эрчимт эмчилгээний тасгуудыг нэн шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах 370 сая төгрөгийн төслийг эхлүүлсэн. Энэ хүрээнд Говьсүмбэр, Өмнөговь, Дорноговь,

Дундговь аймгуудын хүүхдийн тасгууд нярайн шарлагын аппарат, инкубатор, дуслын аппарат, билиметр гэх мэт нэн шаардлагатай, олдоц, хүрэлцээ муутай байдаг тоног төхөөрөмжүүдээр хангагдана.

Говь нутгийн онгон байгаль, зэрлэг ан амьтдыг сурталчлан таниулах, баримтжуулах зорилгоор Хүрээлэн төслийн багтай хамтран “Говийн 5 гайхамшиг” ТВ контентийн төслийг эхлүүлсэн бөгөөд төсөлд шаардлагатай тоног төхөөрөмжийн шинэчлэл хийхэд зориулж нийт 300 гаруй сая төгрөгийн санхүүжилтийг олгосон.

### **“Ид шидийн орон-II” төсөл**



Ухаа худаг уурхайн 10 жилийн ойг тохиолдуулан нийгмийн суурь асуудлуудыг шийдэхэд урт хугацааны өгөөж өгөх ажлуудыг өрнүүлж хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Лантуун Дохио” ТББ-ын хэрэгжүүлж буй “Ид шидийн орон-2” төслийн нийт санхүүжилтийн 50 хувь буюу 740 сая төгрөгийг хандивлалаа. Уг төсөл Улаанбаатар хотын зүүн хязгаар болох Баянзүрх дүүрэг, Улиастайн эцэст хэрэгжих бөгөөд нийт 4,200 мкв талбайд хүүхэд хамгаалал хөгжлийн төв, спорт комплекс, тоглоомын талбай, ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэн болон түр байрлах байрнаас бүрдсэн цогц төв сүндэрлэх юм.

### **Говийн бүсийн эмнэлгүүдийг нярайн тоног төхөөрөмжөөр хангах төсөл**

Тэмдэглэлт ойн хүрээнд хүүхдийн эрүүл мэндийн төлөө эхлүүлсэн бас нэгэн төсөл бол говийн бүсийн эмнэлгүүдийг нярайн тоног төхөөрөмжөөр хангах



явдал юм. Компанийн зүгээс “Эрүүл үрс, гэрэлт ирээдүй” ТББ-тай хамтран говийн бүсийн аймгуудын хүүхдийн эрчимт эмчилгээний тасгуудыг нэн шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах 370 сая төгрөгийн төслийг эхлүүлсэн. Төслийн хүрээнд Говьсүмбэр, Өмнөговь, Дорноговь, Дундговь аймгуудын хүүхдийн тасгууд нярайн шарлагын аппарат, инкубатор, дуслын аппарат, билиметр гэх мэт нэн шаардлагатай, олдоц, хүрэлцээ муутай байдаг тоног төхөөрөмжүүдээр хангагдахаар болсон.

### “Говийн 5 гайхамшиг” төсөл



Ухаа худаг уурхай нь Өмнөговь аймгийн Цогтцэций суманд үйл ажиллагаа явуулдаг бөгөөд энэ ч утгаараа говь нутгийн онгон байгаль, зэрлэг ан амьтдыг хамгаалах чиглэлээр тасралтгүй үйл ажиллагаа явуулдаг. 2018 онд компанийн зүгээс Монголын говийн зэрлэг байгаль, ан амьтдыг олон нийтэд таниулах, баримтжуулах зорилготой “Говийн 5 гайхамшиг” ТВ контентийн төслийг эхлүүлсэн бөгөөд төсөлд шаардлагатай тоног төхөөрөмжийн шинэчлэл хийхэд зориулж нийт 300 гаруй сая төгрөгийн хандивыг олгосон.

# Компанийн нийгмийн хариуцлага

Энержи Ресурс компанийн хувьд олон улсын болон Монгол Улсын холбогдох хууль тогтоомжуудын хүрээнд хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг хэрэгжүүлж, нийгмийн сайн сайхан, улс орны эдийн засгийн хөгжилд урт хугацааны, бодитой хувь нэмэр оруулах замаар тогтвортой хөгжлийн бат бэх суурь бий болгохыг зорьдог.

Олон Улсын Стандартын Байгууллагаас 2010 оны 10-р сард гаргасан "ISO26000: Нийгмийн хариуцлагын зөвлөмж" болон Олон Улсын Санхүүгийн Корпораци, Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк зэрэг байгууллагуудаас гаргасан удирдамжуудад үндэслэн КНХ-ын бодлогоо боловсруулан батлуулж, хэрэгжүүлсээр ирсэн.

Орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжих зорилгын хүрээнд дэд бүтэц, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, боловсролыг дэмжих, соёлын өвийг хамгаалах, жижиг дунд бизнесийг дэмжих үндсэн чиглэлүүдээр төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлж байна.

Энэ хүрээнд иргэд, оролцогч талуудтай зөвлөлдөх, компанийн үйл ажиллагааны талаар үнэн зөв мэдээллийг түгээх, орон нутгийн иргэд,

## ISO:26000

Олон улсын нийгмийн хариуцлагын зөвлөмжийн дагуу КНХ-ын бодлогыг хэрэгжүүлэн ажилладаг.

## КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Компанийн сайн засаглалыг төлөвшүүлэх нь манай компанийн хувьд дэлхийн жишигт нийцсэн уул уурхайн үйлдвэрлэлийн цогцолбор байгуулан, улсдаа тэргүүлэгч аж ахуйн нэгж байх гол тулгуур хүчин зүйл гэж бид үздэг.

Энэ бодлогын бодлогын хүрээнд дотоодын болон олон улсын сайн засаглалын шаардлага, стандартуудыг мөрдөхийн зэрэгцээ шийдвэр гаргалтын оновчтой, энгийн, түргэн шуурхай орчныг бүрдүүлэх байдлаар дотоод дүрэм, журмуудын хэрэгжилтийг ханган ажилладаг.

Түүнчлэн оролцогч, сонирхогч талуудын итгэлийг хүлээх үүднээс нээлттэй, ил тод үйл ажиллагаа явуулахыг эрхэмлэдэг. Энэ хүрээнд үйл ажиллагаагаа олон нийт, хөрөнгө оруулагчид болон бусад төр засаг, олон улсын банк санхүүгийн байгууллагуудад нээлттэй тайлагнасаар ирсэн. 2009 онд үйл ажиллагаагаа эхлүүлснээс хойш Олборлох Үйлдвэрлэлийн Ил



Тод Байдлын Санаачилга (ОУИТБС)-д нэгдэн, төр засгийн байгууллагад төлсөн төлбөр, татвар хураамжаа жил бүр ил тод, нээлттэй тайлагнаж, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх үйлсэд нэгдэн ажиллаж байна.

2018 онд бид Германы Конрад-Аденауэр-Сан болон Компанийн Засаглалын Хөгжлийн Төвөөс санаачилсан “Компанийн нийгмийн хариуцлага, тогтвортой хөгжлийн зорилтууд” санаачилгад Монголын тэргүүлэх аж ахуйн нэгжүүдийн хамтаар нэгдэн орлоо. Энэхүү санаачилга нь Монгол Улсын тогтвортой хөгжилд бизнесийн байгууллагуудын оруулах хувь нэмрийг тодорхойлж, өргөтгөөд зогсохгүй компанийн сайн засаглал, нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх зорилготой юм.

## НЭЭЛТТЭЙ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

2009 оноос орон нутгийн нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлгийг зохион байгуулж ирсэн.

## ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Энержи Ресурс компани нь оролцогч, сонирхогч талуудыг татан оролцуулах төлөвлөгөөг 2009 оноос эхлэн хэрэгжүүлж эхэлсэн. Энэхүү төлөвлөгөөнд дараах үндсэн зарчмуудыг тусгасан байдаг:

- Орон нутгийн иргэд Ухаа худаг төслийн талаар мэдээлэл авах эрхийг хангаж ажиллах;
- Бодлого, төлөвлөлтөндөө оролцогч, сонирхогч талуудын санал хүсэлтийг тусгах зарчмыг баримтлан, үр дүнтэй хэлэлцүүлгийг аливаа шахалт дарамтгүйгээр, шударгаар явуулах;
- Үйл ажиллагааныхаа нийт хугацааны туршид оролцогч, сонирхогч талуудын оролцоог хангах чиглэлийн үйл ажиллагааг тогтмол явуулах;
- Иргэдийн санал хүсэлт, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх механизмыг бий болгон хэрэгжүүлэх.



Эдгээр зарчмуудын хүрээнд компанийн үйл ажиллагааны талаар үнэн, зөв мэдээлэл түгээж, иргэдтэй нүүр тулж уулзан, тэдний санал зөвлөмжийг үйл ажиллагаандаа тусгах зорилгоор Монголын уул уурхайн салбарт анх удаа Орон нутгийн нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлгийг 2009 оноос эхлэн жил тутам зохион байгуулж ирсэн.


Мөн орон нутгийн иргэдтэй нээлттэй харилцааг хөгжүүлж, шийдвэр гаргах явцад тэдний оролцоог хангах, дуу хоолойг тусгах үүднээс Цогтцэций, Баян-Овоо, Ханбогд сумдад орон нутгийн сайн дурын зөвлөл (ОНЗ) байгуулан тууштай хамтран ажиллаж байна.

Малчид, иргэдийг компанийн бүтээн байгуулалтын ажлууд болон байгаль орчны мониторинг, гар худаг болон тоосны хэмжилт, нөхөн сэргээлтийн ажилд сайн дураараа хяналт тавих байдлаар тогтмол оролцуулдаг нь компани ба иргэд хоорондын харилцан ойлголцол, итгэлцлийг нэмэгдүүлэхэд эергээр нөлөөлж байна.

### ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ БАРАГДУУЛАХ МЕХАНИЗМ



### ХҮСЭЛТ, ГОМДОЛ



Компанид орон нутгийн иргэд болон ажиллагсдаас ирсэн гомдлыг хүлээн авч шуурхай шийдвэрлэж эргэн мэдээлэх журам хэрэгждэг. Аливаа өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор хариу өгч, шаардлагатай болон хүсэлт гаргасан тохиолдолд гомдлын нууцлалыг хадгалах ба бүх гомдолд ижил тэгш зарчмаар ханддаг.

2018 онд компанийн хэмжээнд нийт 16 хүсэлт хүлээн авсан байна. Эдгээрээс санхүүгийн дэмжлэг, нүүрс болон бусад туслалцаа хүссэн хүсэлтүүд нийт өргөдлүүдийн 75 хувийг, уурхайн бүтээн байгуулалттай танилцах, ажилд орох, худаг устай холбоотой хүсэлтүүд үлдсэн 25 хувийг эзэлж байлаа. Бүх саналыг 30 хоногийн дотор шийдвэрлэж, тухай бүр хариу

## ₮1.2 их наяд

Ухаа худаг төслийн хүрээнд  
2010-2018 онд хийсэн  
нийт хөрөнгө оруулалт

мэдээлсэн. Судалгаагаар жил ирэх тусам ард иргэдээс ирэх гомдлын тоо эрс багасч, санал хүсэлтийн тоо нэмэгдэж байгаа нь компанийн зүгээс хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг бодитой хэрэгжүүлж, нээлттэй, олон талт харилцааг хөгжүүлэн ажиллаж ирсний бодит үр дүн юм.

### ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛД ОРУУЛЖ БУЙ ХУВЬ НЭМЭР

Энержи Ресурс компани нь үйл ажиллагаа эхлүүлснээс хойш татвар төлөлт, эдийн засагт оруулж буй хувь нэмрийн хэмжээгээр Монгол Улсын ТОП 5 аж ахуйн нэгжээр тогтмол шалгарч, улс орны хөгжил, эдийн засгийн өсөлтөнд бодит хувь нэмрээ оруулж ирсэн. Тодруулбал, 2009-2018 он хүртэлх арван жилийн хугацаанд нийт 1.1 их наяд төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Зөвхөн 2018 онд л гэхэд татвар, шимтгэл хэлбэрээр нийт 219 тэрбум төгрөгийн татварыг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Орон нутаг төдийгүй улс орны хэмжээнд хөгжлийн чухал хөшүүргүүдийн нэг нь дэд бүтцийн асуудал байдаг. Энержи Ресурс компани үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш Ухаа худагт өргөн цар хүрээтэй бүтээн байгуулалтыг өрнүүлж, уурхай дагасан дэд бүтцийн шийдлийг цогцоор бүрдүүлсэн. Тухайлбал, Монгол инженерүүдийн ур ухаанаар дулааны цахилгаан станц, усан хангамжийн систем барьж байгуулснаар орон нутгийн иргэд 24 цагийн найдвартай эрчим хүч, цэвэршүүлсэн усаар хангагдах болсон.

Мөн орон сууцны “Цэций” хороолол, сургууль цэцэрлэгийн “Мөрөөдөл” цогцолборыг барьж байгуулснаар ажиллагсад болон орон нутгийн иргэд ая тухтай амьдрах, хүүхэд багачууд говийн алслагдмал суманд ч тохилог орчинд, чанартай боловсрол олж авах нөхцөл боломж бүрдсэн.

Өнгөрсөн онд нийт 274 аж ахуйн нэгжээс хэрэгцээт бараа, үйлчилгээ худалдан авсны 93 хувь нь үндэсний компаниуд байсан бол Өмнөговь аймаг буюу орон нутгийн хэмжээнд 27 аж ахуйн нэгжээс нийт 3.6 тэрбум төгрөгийн бараа материал, ажил үйлчилгээний худалдан авалт хийжээ.

### Орон нутагт оруулсан хөрөнгө оруулалтын дүн /2018/



Хөрөнгө оруулалтын чиглэл	/мян.төг/
Орон нутгийн дэд бүтэц	3,113,978.9
Орон нутгийн хөгжлийг дэмжих төсөл, хөтөлбөрүүд	738,387.7
Хандив, тусламж	287,600.0
Орон нутгийн худалдан авалт	3,617,440.0
<b>Нийт</b>	<b>7,753,406.5</b>

## НИЙГЭМ, ОРОН НУТАГТ ЧИГЛЭСЭН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮД

Энержи Ресурс компани нь боловсрол, хүн ам, эрүүл мэнд, хүний эрх, соёлын өв зэрэг нийгмийн олон чиглэлийн суурь судалгаа болон иргэдийн нээлттэй хэлэлцүүлгийн санал санаачлагыг үндэслэн орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжих төсөл, хөтөлбөрүүдийг орон нутгийн иргэд, олон нийт болон засаг захиргааны байгууллагуудтай хамтран хэрэгжүүлдэг.

Тайлант онд иргэд, засаг захиргааны байгууллага, харилцагч, нийлүүлэгчидтэй "сайн хөрш"-ийн харилцааг эрхэмлэж, малчин өрхүүдэд өвс тэжээлийн тусламж үзүүлэх, сар шинээр өндөр настнуудад гарын бэлэг гардуулах зэрэг ажлуудыг жил бүр уламжлал болгон зохион байгуулж, орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжих төсөл, хөтөлбөрүүдээ тууштай үргэлжлүүлж ажиллалаа.

### Орон нутгийн боловсролыг дэмжих хөтөлбөр

#### МУБИС-ийн математикийн тэнхимийн эрхлэгч, зөвлөх багш Ж.Сандагдорж:

"Анх Энержи Ресурс компаниас "Мөрөөдөл" сургуулийн математикийн хичээлийн чанарыг сайжруулахад хамтран ажиллах санал тавьсны дагуу зөвлөхөөр ажиллах болсон. Бид Мөрөөдөл цогцолбороос гадна Т.Борын нэрэмжит сургуулийн математикийн хичээлийн чанарыг сайжруулахад анхаарч байгаа. Үйл ажиллагаа явуулж буй орон нутгийнхаа боловсролд анхаарч, сургууль байгуулаад зогсохгүй менежментэд нь санаа тавьдаг үндэсний компанитай хамтарч байгаадаа баяртай байна. Бэлтгэсэн хүүхдүүд маань аймгийн болон улсын чанартай олимпиадад амжилттай оролцож, эхнээсээ бодит үр дүн гарч эхэлсэн"



Энержи Ресурс компани 2013 онд Өмнөговь аймгийн ЗДТГ-тай хамтран Цогтцэций суманд "Мөрөөдөл" сургууль, цэцэрлэгийн цогцолбор байгуулж өгөөд зогсохгүй Улаанбаатар хотоос туршлагатай багш, ажиллагсдыг урьж ажиллуулах, англи хэл, математикийн гүнзгийрүүлсэн сургалт нэвтрүүлэх зэргээр боловсролын менежментийн цогц хөтөлбөр хэрэгжүүлж ирсэн. Тайлант онд МУБИС-ийн математикийн тэнхимийн эрхлэгч Ж.Сандагдорж багштай зөвлөхийн гэрээ байгуулан, Мөрөөдөл цогцолбор болон Т.Борын нэрэмжит ЕБС-иудын математикийн хичээлийн сургалтын чанарыг сайжруулах, багш сурагчдын амжилтыг ахиулах чиглэлээр хамтран ажиллаж эхэлсэн. Цаашид "Мөрөөдөл" сургуулийн багш нарт үр дүнгийн урамшуулал олгох, менежментийн мэргэшсэн зөвлөх ажиллуулах зэргээр орон нутгийн боловсролын чанар, хүртээмжийг сайжруулахаар зорин ажиллаж байна.

### "Амралтаараа ажиллая" цалинтай оюутан хөтөлбөр

Өмнөговь аймгийн Цогтцэций сумын оюутан залууст амралтаараа ажил эрхлэх,

нэмэлт орлого олох боломж олгох, улмаар тэдгээрийг хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор 2018 онд “Амралтаараа ажиллая” хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлж эхэлсэн. Хөтөлбөрийн хүрээнд зуны турш Ухаа худаг уурхайн 11 алба хэсэгт нийт 22 оюутныг мэргэжлийн чиглэлийн дагуу дадлагажуулж ажиллуулсан. Оюутнууд мод үржүүлгийн талбай, оффис, төслийн нэгжүүдэд ажиллаж, ажил хөдөлмөрийн туршлага хуримтлуулсан юм.

### Ухаа худаг наадам – 2018



Энержи Ресурс компаниас орон нутгийн иргэдэд хүндэтгэл үзүүлэх, соёлын өв, уламжлалт ёс заншлыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор Ухаа худаг наадмыг жил бүр зохион байгуулдаг ба наадмын цар хүрээ жилээс жилд өргөжиж, нутаг нутгийн хүчит бөхчүүд, алдарт уяачид, эрхийн мэргэн харваачид оролцдог болсон.

Бид Ухаа худаг-2018 наадмыг 10 жилийн ойгоо тохиолдуулан Өмнөговь аймгийн зүүн бүсийн сумдыг хамруулан Цогтцэций суманд өргөн дэлгэр зохион байгууллаа. Наадамд хүчит 128 бөх, өсвөрийн 32 бөх барилдаж, таван насны хурдан морины уралдаан болж, халх сурын харваанд 70 гаруй эрхий мэргэн харваачид цэц мэргэнээ сорьсон. Мөн “Цэцийн жонон” морин хуурын хамтлаг, Ханхонгор сумын урлагийн сургуулийн сурагчид, аймгийн ХЖТ-ын уран бүтээлчид гээд нутгийн олон авьяастнууд оролцож, түүх, соёлын баялаг уламжлалтай говь нутгийнхаа өв соёлыг сурталчлан таниулав. Уламжлал ёсоор наадамчин олны дунд үндэсний хувцсаараа гоёсон сайхан хосыг шалгаруулж, наадмын нээлт, хаалт, үдшийн цэнгүүнд урлагийн алдартнуудын төлөөлөл оролцож, баяр наадмыг чимж, наадамчин олныг баясган цэнгүүлсэн юм.

## Эрүүл мэндийн үзлэг

БНСУ-ын Пусан хотын Пусанжин дүүргийн эрүүл мэндийн газар болон хувийн хэвшлийн эмнэлгүүдийн эмч нар сайн үйлсийн аяны хүрээнд Цогтцэций суманд ажиллан шүд эрүү нүүр, мэдрэл үе мөч, арьс гоо засал, гоо сайхны мэс засал зэрэг чиглэлээр анхан шатны үзлэг хийж зөвлөгөө өглөө. Арга хэмжээний үеэр сумын 163 иргэн анхан шатны үзлэгт хамрагдаж, зөвлөгөө авч үйлчлүүлсэн. Түүнчлэн сум дундын эмнэлэг болон өрхийн эмнэлэгт мэдээлэл хүргэснээр түлэгдэлтийн дараах соривжилттой, арьсны асуудалтай, мэдрэл, үе мөчний чиглэлээр үзүүлэх шаардлагатай иргэдэд мэдээлэл хүргэн зорилтот бүлэгт чиглэсэн үйлчилгээг үзүүллээ.

## “Сайн хөрш”-ийн хамтын ажиллагаа



“Сайн хөрш” хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн оролцогч талуудтай тогтмол хамтран ажилласаар ирсэн. Сар шинийн баярыг угтан уламжлал ёсоор уурхайн удирдлагууд сумдын Ахмадын хороотой хамтран нутгийн өндөр настнуудад хүндэтгэл үзүүлсэн. Тодруулбал Цогтцэций, Ханбогд, Баян-Овоо, Ханхонгор сумдын 70-аас дээш насны 380 ахмадыг хүлээн авч, санал солилцон гарын бэлэг гардууллаа. Мөн говь нутгаар өвөлжилт хүндэрч, цас зудтай байсантай холбогдуулан нийгмийн хариуцлагын хүрээнд Өмнөговь аймгийн Ханбогд, Баян-Овоо, Ханхонгор, Цогтцэций, Манлай, Номгон сумдын малчдад 8,000 боодол өвс, 1,650 уут хивэг тэжээлийн тусламж үзүүллээ. Мөн 5 сумын фондод тус бүр 700 боодол өвс, 100 уут тэжээл хандивласан.

## Үерийн гамшигт өртөгсдөд тусламж

2018 оны зуны улиралд Өмнөговь аймагт орсон хүчтэй борооны улмаас Хүрмэн, Ханхонгор, Цогтцэций сумын нийт 11 малчин өрх үерт нэрвэгдэж гэр орон, мал ахуйгаа алдан, хохирол амссан. Эдгээр өрхүүдэд туслахыг



Цогтцэций сумын засаг захиргаанаас олон нийтэд уриалсны дагуу Энержи Ресурс компанийн зүгээс гамшигт өртсөн 11 өрхийн төлөөллийг хүлээн авч уулзан, нийт 10 сая төгрөгний бэлэн мөнгөний тусламж үзүүллээ.

### Ус, эрчим хүчний хангалт



“Сайн хөрш” хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн төрийн болон ТББ-ууд, оролцогч талуудтай тасралтгүй хамтын ажиллагаа хөгжүүлж ирсэн. 2009 оноос өмнө байнгын тог цахилгаангүй байсан Цогтцэций сумыг 24 цагийн цахилгаан эрчим хүч, ундны цэвэршүүлсэн усаар найдвартай хангаж ирсэн. Дунджаар авч үзвэл, жил бүр 30,000 м3 цэвэршүүлсэн ус, 7 сая кв/ цаг цахилгаан эрчим хүчийг орон нутагт улсын суурь үнээр нийлүүлж, жил бүр 1 тэрбум орчим төгрөгийн зардал гаргаж байна. Мөн, Өмнөговь аймгийн Даланзадгад болон Ханбогд, Ханхонгор, Баян-Овоо сумдад өвөлжилтийг өнтэй давахад зориулан эрчим хүчний нүүрс үнэ төлбөргүй нийлүүлж ирсэн. Тайлант онд Даланзадгадын дулааны цахилгаан станц болон Өмнөговийн сумдын өвөлжилтийн хэрэгцээнд нийт 470 орчим сая төгрөгийн өртөг бүхий 38,000 тонн эрчим хүчний нүүрс нийлүүлсэн байна.

# Ажлын байр

Энержи Ресурс компани нь Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу ажиллагсдыг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад тохирсон, ажлын байрны дарамтнаас ангид нөхцлөөр хангах, хөдөлмөрийн үр дүнд нь тохирсон цалин хөлс олгох, нийгмийн даатгалд даатгуулах зэрэг үндсэн заалтуудыг чандлан мөрдөхийн зэрэгцээ манай улсын нэгдэн орсон Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын конвенц болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад акт, хамтын гэрээ хэлэлцээрийг дагаж биелүүлдэг.

## Энержи ресурс компанийн оператор **Б.Билэгсайхан**

"Би Ухаа худаг уурхайн эмэгтэй операторын сургалтанд хамрагдсан анхны сурагчдын нэг. Дадлага хийхдээ анх дам-аа хараад их сүрдэж, битүүхэн айж байсан. Гэхдээ өөрөө жолооч болох маш их хүсэл сонирхолдоо хөтлөгдөж, сургалтанд хамрагдсан болохоор удалгүй техникээ сайн эзэмшиж, өөрийн болгосон. Ямар ч байсан өөрийн хүссэн, зорьсондоо хүрээд төрөлх нутагтаа компанийнхаа бүтээн байгуулалтад оролцоод явж байгаа би их азтай хүн. Анх Баян-Овоо сумаасаа Ухаа худагт ганц үүргэвчтэй ирж байсан бол өнөөдөр хоёр хүүхэдтэйгээ, гэр бүлээрээ тохиллог байр сууцанд сайхан амьдарч явна даа"



## АЖЛЫН БАЙР, ТЭГШ БОЛОМЖ


Тус компани нь хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг хэрэгжүүлэгчийн хувьд ажиллагсдын эрхийг дээдэлж, тэднийг ижил тэгш боломжоор хангадаг. Ажилтан, ажиллагсдыг сонгон шалгаруулахдаа ажил горилогсдын мэргэжил, ур чадварын түвшинг эн тэргүүнд харгалзан үзэхээс гадна орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах чиглэлд онцгой анхаарал хандуулж ирсэн. 2018 оны 12-р сарын байдлаар



тус компани нийт 1,938 үндсэн ажиллагсадтай байсны 44 хувийг орон нутгийн иргэд, тодруулбал Өмнөговь аймгийн Цогтцэций, Даланзадгад, Манлай, Баян-Овоо, Цогт-Овоо сумын иргэд зонхилон бүрдүүлж байна.

Компанийн хөдөлмөрийн дотоод журмын дагуу ажилтны нас, хүйс, шашин шүтлэг, улс төрийн үзэл баримтлал, оршин суугаа орон нутаг, харьяалал зэргээс үл хамаарсан цалин, хөлс олгож, тэгш хөгжих боломжийг хангадаг бөгөөд цалингийн зөрүү нь зөвхөн тухайн ажилтны боловсрол, ур чадварын түвшин, туршлага болон зэрэг, дэв зэргээс хамаардаг.


### Компанийн ажиллагсдын мэдээлэл (2016-2018)




	2016	2017	2018
1 Нийт ажиллагсад	1,442	1,797	1,938
2 Нийт эмэгтэй ажиллагсад	219	227	272
3 Удирдах түвшний эмэгтэй ажиллагсад	34	33	32
<b>4 Орон нутгийн ажиллагсдын эзлэх хувь</b>	<b>63%</b>	<b>47%</b>	<b>44%</b>

Тайлант онд нийт ажиллагсдын 14%-ийг эмэгтэй ажиллагсад бүрдүүлсэн бөгөөд тэдгээрийн 11% нь менежер болон удирдах түвшинд, 46% нь мэргэжилтэн буюу нарийн мэргэжил ур чадвар шаардсан ажил албан тушаалд, 43% нь мэргэжилтэй ажилчин буюу ямар нэгэн нарийн мэргэжил шаардахгүй ажилчны түвшинд тус тус ажиллаж байна. Энэ нь дотоодын төдийгүй олон улс дахь уул уурхайн салбарын дунджаас дээгүүр үзүүлэлт бөгөөд менежер ба удирдах түвшинд эмэгтэйчүүдийн оролцооны хувь хэмжээг тогтмол өсөлттэй хадгалж ирлээ. Насны ангиллаар нь авч үзвэл нийт ажиллагсдын дийлэнхи буюу 65%-ийг 18-35 насныхан, 35%-ийг 35 болон түүнээс дээш насныхан бүрдүүлж байна.

### Эмэгтэй ажиллагсдын мэдээлэл (2016-2018)



## ОРОН НУТГИЙН АЖИЛЛАГСДЫН ЭЗЛЭХ ХУВЬ /2018/



## НИЙГМИЙН ХАЛАМЖ

Компанийн зүгээс ажиллагсдын цалин хангамж, урамшуулал болон нийгмийн халамжийн чиглэлээр тодорхой бодлого, журмыг хэрэгжүүлэн ажилладаг. Бид өнгөрсөн 10 жилийн хугацаанд говь нутагт нийгмийн дэд бүтцийг бий болгох чиглэлд Цогтцэций суманд орон сууцны болон гэр хороолол, сургууль цэцэрлэг зэргийг цогцоор нь бүтээн байгуулсан бөгөөд зөвхөн нэг ажилтны ажиллаж, амьдрах орчинг бүрдүүлэхэд хамгийн багадаа 50 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн болохыг судалгаагаар тогтоожээ.

Тухайлбал, нийт ажилтнууддаа орон сууц худалдан авахад нь банкны хөнгөлөлттэй зээл олгох, даатгал, эрүүл мэндийн үзлэгт хамруулах, гэр бүлээрээ нүүн суурьшиж буй ажилтнуудын гэр бүлийг ажилд ороход нь дэмжлэг үзүүлэх, мөн ажиллагсдын хүүхдүүдийн сургууль цэцэрлэгийн асуудлыг шийдэхэд нь тусламж, дэмжлэг үзүүлэх зэргээр ажиллагсдын нийгмийн асуудалд нэн тэргүүнд анхаарал хандуулсаар ирсэн.

## ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН

2018 онд шинээр 770 хүнийг ажлын байраар хангасан бөгөөд ингэснээр ажиллагсдын шилжилт хөдөлгөөний жилийн үзүүлэлт 8%-тай байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад гурав дахин буурсан үзүүлэлт бөгөөд компанийн зүгээс ажиллагсдынхаа нийгмийн асуудалд анхаарч, хөнгөлөлт, хангамжийн бодлогоо хэвээр хадгалан, гэр бүлээр нь орон нутагт шилжүүлэн суурьшуулах хөтөлбөрөө үргэлжлүүлэн хэрэгжүүлсний үр дүн юм.

Мөн орон сууцны "Цэций" хороололд 40 ажилтныг, "Уурхайчин" хороололд 51 ажилтныг гэр бүлийн хамт тус тус суурьшуулсан. Тогтвортой



ажиллах гэрээний үүргээ биелүүлсэн 11 ажилтанд орон сууц, 33 ажилтанд хашаа газрын өмчлөлийг үнэ төлбөргүй шилжүүлж өгсөн байна.

Ажилтнуудыг суурьшуулах болон орон сууц, хашаа газрын өмчлөлийг шилжүүлэхтэй холбоотой зардалд нийт 593 сая төгрөг зарцуулжээ. Компанийн нийт ажилтнуудын 50% нь тогтвор суурьшилтайгаар 5 болон түүнээс дээш жил ажиллаж байгаа нь компанийн зүгээс хүний нөөцийн бодлогодоо онцгойлон анхаарч, ажилтнуудаа ижил, тэгж боломжоор хангаж ирсний үр дүн юм.

## СУРГАЛТ ХӨГЖИЛ

Компани байгуулагдсан цагаас эхлэн мэргэжилгүй иргэдийг уул уурхайн чиглэлээр мэргэшүүлж, ажлын байраар хангах, ажилтнуудынхаа мэргэжлийн ур чадварыг сайжруулах, хувь хүний ерөнхий ур чадварыг нэмэгдүүлэх, байгууллагын соёлыг төлөвшүүлэх сургалтуудыг тогтмол зохион байгуулсаар ирсэн. Тайлант онд ерөнхий ур чадварын болон нарийн мэргэжлийн нийт 108 төрлийн сургалтанд давхардсан тоогоор 15,656 ажиллагсдыг хамруулсан нь өнгөрөгч оныхоос даруй 958 хувиар өссөн үзүүлэлт юм. Тодруулбал 90,171 хүн/цаг сургалт явагдсан бөгөөд нэг ажилтанд дунджаар 6 цагийн сургалт ногдож байна. Давхардсан тоогоор нийт 1,878 эмэгтэй ажиллагсдыг сургалтанд хамруулсан байна.

### Сургалтын мэдээлэл /2016-2018/

Сургалтад хамрагдсан хүний тоо	2016	2017	2018
1. Нарийн мэргэжлийн сургалт	319	1,238	6,773
2. Ерөнхий ур чадварын сургалт	10	396	8,883
<b>Нийт</b>	<b>329</b>	<b>1,634</b>	<b>15,656</b>




# Ханган нийлүүлэлт, худалдан авалт

Орон нутгийн тогтвортой хөгжил, эдийн засгийг дэмжих нэг хэлбэр нь орон нутгийн аж ахуйн нэгж, иргэдээс бараа бүтээгдэхүүн худалдан авах явдал юм. Компанийн зүгээс бараа бүтээгдэхүүн худалдан авахдаа бизнесийн шударга зарчмыг баримталж, орон нутгийн бизнес эрхлэгчидтэй хамтрахыг нэн тэргүүнд зорьдог.

## ҮЙЛ АЖИЛЛАГАА


Энержи Ресурс компани нь Ухаа худаг төслийн хүрээнд дотоодын нийт 4,000 гаруй аж ахуйн нэгжтэй бэлтгэн нийлүүлэгч, туслан гүйцэтгэгч хэлбэрээр хамтран ажиллаж ирсэн. Зөвхөн 2018 оны байдлаар нийт 300 орчим аж ахуйн нэгжээс 220 орчим тэрбум төгрөгийн хэрэгцээт бараа, үйлчилгээг худалдан авсны 90 гаруй хувь нь буюу 275 нь дотоодын аж ахуйн нэгж, компаниуд байсан үзүүлэлттэй байна. Тайлант хугацаанд Өмнөговь аймгийн хэмжээнд орон нутгийн 27 аж ахуйн нэгжээс нийт 3.6 тэрбум төгрөгийн худалдан авалт хийсэн нь өнгөрсөн оноос даруй гурав дахин өссөн үзүүлэлт юм.

### ХАНГАН НИЙЛҮҮЛЭГЧ АЖ АХУЙН НЭГЖҮҮД /2018/



- Гадаад
- Өмнөговийн
- Дотоод

### Өмнөговь аймгаас хийсэн худалдан авалт /2016-2018/



Мөн компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд үндэсний болон орон нутгийн жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжихэд чиглэсэн дараах төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн ажилладаг.

### Иргэдийн тогтвортой амьжиргааг дэмжих хөтөлбөр

Энержи Ресурс компани нь 2014 оноос Хас банктэй хамтран орон нутгийн малчид, иргэдийн жижиг, дунд бизнесийг дэмжих зорилгоор "Малчдын тогтвортой амьжиргааг дэмжих хөтөлбөр"-ийг эхлүүлсэн. Энэ хугацаанд

### **“Зул” оёдлын цехийн захирал С.Зул**

*"Анх 2017 онд оёдлын цехийн ажлаа дөнгөж эхлүүлж байсан бол одоо 20 орчим ажилтантай болж өргөжсөн. Одоо уурхайчдын ажлын хувцас, нүүрсний бүтээлэг голдуу өгж байна. 2018 онд Энержи Ресурс компанийн "Иргэдийн тогтвортой амьжиргааг дэмжих хөтөлбөр"-т хамрагдаж хүүгүй 10 сая төгрөгийн зээл авч байсан. Жижиг, дунд бизнес эрхлэгчдэд хүүгийн дарамтгүй зээл гэдэг асар том боломж. Үйл ажиллагаагаа эхлүүлэх, өргөжүүлэхэд бодит дэмжлэг үзүүлж буй Энержи Ресурсын хамт олонд баярлалаа"*



орон нутгийн 36 иргэнд нийт 206 сая төгрөгийн хүүгүй зээл олгосон байна. Уг санхүүжилтийн хүүнд иргэдийн өмнөөс нийт 15 сая төгрөгийг компани банкинд төлсөн бөгөөд 2018 оноос уг хөтөлбөрийг “Иргэдийн тогтвортой амьжиргааг дэмжих хөтөлбөр” болгон өргөжүүлж малчдаас гадна жижиг дунд бизнес эрхлэх хүсэл сонирхолтой иргэд болон шилжин суурьшсан ажиллагсдын гэр бүлийн гишүүдийг дэмжин ажиллаж эхэллээ. Хөтөлбөрт хамрагдагсад хүүгүй зээл олгоод зогсохгүй бизнесээ амжилттай явуулахад нь орон нутгийн “Амжилтын томъёо” ТББ хамтран ажиллаж, бизнесийн сургалт, зөвлөгөөг тогтмол өгч ажилладаг. Тайлант онд зээлийн санд 50 сая төгрөг нэмэлтээр байршуулж, нийт 7 иргэний жижиг, дунд бизнесийг дэмжин тус бүр 5-10 хүртэлх сая төгрөгийн хүүгүй зээлэнд хамрууллаа.

### **Газар тариалан эрхлэлтийг дэмжих төсөл**

#### **Цогтцэций сум, Цагаан-Овоо багийн иргэн Н.Наранцэцэг**

*"Би Энержи Ресурс компаниас орон нугийн иргэдэд хувиарлаж өгсөн ойн зурваст 5 жил ногоо тарьж байна. Голдуу төмс, лууван гэх мэт хүнсний ногоо тариалдаг. Одоо нийтдээ 3 га газарт ногоо тарьж байгаа. Одоо өөрийн гэсэн үйлчлүүлэгчидтэй болсон. Ойр хавийн уурхай болон дэлгүүрийн эзэд ирээд миний ногоог худалдан авчихдаг. Жилдээ 10 гаруй сая орчим төгрөгний борлуулалт хийдэг"*



Орон нутгийн жижиг дунд бизнесийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд өрхийн орлогыг нэмэгдүүлэх, газар тариалан эрхлэлтийг дэмжих урт хугацааны бодлогоор ойн зурвас байгуулж, газар тариалангийн төсөл хэрэгжүүлдэг. Уг төслийн хүрээнд 8 га газарт давхардсан тоогоор нийт 184 өрх төмс, хүнсний ногоо тариалдаг бөгөөд улмаар усалгааны системийн шинэчлэл хийж, иргэдэд зориулан ногоо тарих, арчлах төрөл бүрийн сургалтууд зохион байгуулж байна. Тайлант онд 4 га талбайд нэг байгууллага, 24 өрх тариалалт хийж, 11 нэр төрлийн 27.5 тонн төмс, хүнсний ногоо хураан авсан. Түүнчлэн шинээр ногоо тариалах 12 өрхийг бүртгэн авч, газар хуваарилсан байна.

# Байгаль орчин

Энержи Ресурс компани нь үйл ажиллагааныхаа бүхий л үе шатанд ажиллагсдын аюулгүй байдал, эрүүл мэндэд учирч болох сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, байгалийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх ажилд нэн тэргүүний ач холбогдол өгч, байгаль орчны чиглэлийн холбогдох бүхий л хууль, стандартуудыг мөрдөж ажилладаг.

Байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (БОХАБЭА)-н хүрээнд олон улсын ISO 14001:2004 “Байгаль орчны удирдлагын тогтолцоо” болон OHSAS 18001:2007 “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоо” стандартын шаардлагатай нийцүүлсэн, нэгдсэн удирдлагын тогтолцоог нэвтрүүлэн ажиллаж байна. Энэхүү нэгдсэн удирдлагын тогтолцоо нь БОХАБЭА-н бодлого, зорилго, зорилт, шаардлага болон тэдгээрт хүрэх арга замыг тодорхойлсон цогц систем тул компаниас хэрэгжүүлж буй бүхий л төсөл, үйл ажиллагаанд хүрч мөрдөгддөг.

## ҮЙЛ АЖИЛЛАГАА


Монгол Улсын хууль тогтоомж болон олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын шаардлагад нийцүүлсэн байгаль орчны нарийвчилсан үнэлгээг Ухаа худаг төсөл эхлэхээс өмнө хийж гүйцэтгэн, төслөөс үүдэлтэй байгаль орчинд учирч болохуйц сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, нөхөн сэргээх зорилготой менежментийн төлөвлөгөө боловсруулсан. Энэ хүрээнд Ухаа худаг уурхайн үйл ажиллагаанд хог хаягдал, ус, тоосжилт, хөрсний элэгдэл, эвдрэл, нөхөн сэргээлт зэрэг чиглэлүүдээр төрөлжсөн менежментийн төлөвлөгөөнүүдийг хэрэгжүүлэн ажиллаж ирсэн.

Тайлант онд Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн дагуу байгаль орчны төлөвлөгөөт аудитыг мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн бөгөөд Ухаа худаг төслийн байгаль орчны хууль эрх зүйн нийцтэй байдлыг 94% буюу хангалттай хэрэгжүүлдэг гэж үнэлсэн.

### Онцлох ажлууд:

- 2018 оны зун говьд хур бороо их орсны улмаас үер, усны гамшиг тохиосон. Ухаа худаг уурхайн усны инженерүүд үерийн усыг тусгай аргаар насосоор цуглуулан, шаврыг тунаасны дараа үйлдвэрийн хэрэгцээнд

### ТАРЬЖ УРГУУЛСАН МОД, БУТ СӨӨГ



эргүүлэн ашигласан. Зуны турш 400,000 орчим куб метр ус цуглуулж, зам усалгаа, баяжуулах үйлдвэр зэрэг уурхайн хэрэгцээнд ашигласан.

- Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 9 төрлийн 5,100 мод сөөгний суулгацыг тарьж ургуулав.
- Орчны хяналт шинжилгээний ажлын хүрээнд малчдын гар худгууд дээр 96 удаа, тоосны хяналтын цэгүүд дээр 84 удаа тус тус хэмжилт хийсэн бөгөөд цооногийн усны 64, тоосны 136 дээж цуглуулж дотоодын лабораторид шинжлүүлсэн.
- Зэрлэг амьтдыг хамгаалах ажлын хүрээнд 4 байрлалд 120 боодол өвс, 100кг хужир байрлуулсан.
- Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд нэмэлт тодотгол хийлгүүлэхээр мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулсан бөгөөд уг ажлын хүрээнд БОАЖЯ-аар ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргуулж, гүйцэтгэгч талд төслийн үйл ажиллагааг танилцуулж, судалгаа хийхэд шаардлагатай мэдээ материалаар хангаж ажиллав.
- Дотоод хяналтын төлөвлөгөөний дагуу 6 хэлтэс алба, 8 гэрээт компанид хяналт хийж 144 үл нийцлийг тодорхойлж, залруулах арга хэмжээний зөвлөмж хүргүүлсэн.
- Хог хаягдлын менежментийн хүрээнд хогийн цэгийн байрлал өөрчлөхтэй холбоотой бэлтгэл ажлыг хангуулж, бүх нийтийн их цэвэрлэгээг 28 га талбайд зохион байгуулж, хог хаягдал түр хадгалах 12 цэгт хамтарсан үзлэг явуулж, ангилан ялгалтыг сайжруулах зөвлөмж хүргүүлэв.

## 20 ГА ТАЛБАЙ

2008-2018 оны хооронд  
ойжуулсан нийт талбай



## Бороо, үерийн усны дахин ашиглалт



  
**23.1 МЯН.ТН**  
үерийн ус хуримтлуулав

2018 оны зун говьд хур бороо их орсны улмаас үер, усны гамшиг тохиосон. Цогтцэций суманд болсон үерийн дараа Ухаа худагийн уурхайчид түргэн шуурхай арга хэмжээ авч, сумын төв болон барилга, байгууламжийн хуримтлагдсан усыг шавхан зайлуулахын зэрэгцээ хамгаалалтын далан, сувгийг сэргээх, шинээр байгуулах ажлуудыг цаг тухайд нь хийж гүйцэтгэжээ. Түүнчлэн усны инженерүүд маань сумын төв, уурхай орчим тогтсон үерийн усыг тусгай аргаар насосоор цуглуулан, шаврыг тунаасны дараа үйлдвэрийн хэрэгцээнд эргүүлэн ашиглаж эхэлжээ. Зуны турш цуглуулсан 400,000 орчим куб метр усыг зам усалгаа, баяжуулах үйлдвэр зэрэг уурхайн хэрэгцээнд ашигласан юм.

## Байгаль орчны хяналт, үнэлгээнд иргэдийн оролцоо



**МОД АМЬДРАЛТЫН  
ХУВЬ**

**85%**



Орон нутгийн иргэдэд байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг танилцуулах, байгаль орчны хээрийн хэмжилтэнд иргэдийг оролцуулах, хэмжилтийн бодитой мэдээллийг иргэдэд өгөх зорилготой сургалт, танилцуулгын ажлыг тогтмол зохион байгуулж ирсэн. Энэ ажлын хүрээнд иргэд компанийн байгаль орчны бодлого болон байгаль хамгаалах ажлын талаарх мэдээллийг тогтмол авч, малчдын худагас усны дээж авч шинжилгээ хийх, усны түвшин хэмжих, орчны тоосжилтийн хэмжилт хийх, дуу шуугианы хэмжилт хийх ажилд биечлэн оролцож байна.

2018 онд Цогтцэций сумын төрийн байгууллагын ажилтнууд, малчид, "Цэций" хорооллын оршин суугчдын төлөөлөл зэрэг



иргэд, олон нийтэд байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг танилцуулж, худгийн усны болон тоосны хэмжилтийг газар дээр нь хийж үзүүлэн, хэмжилтийн бодит үр дүнг танилцуулсан.

### Зэрлэг амьтдыг ундаалах уст цэг

Өмнөговь аймгийн Ханбогд суманд өвлийн улиралд зэрлэг ан амьтдыг өлдөж, харангадах аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор уст цэгийг байгуулсан байна. Энержи Ресурс компани болон тус сумын "Говийн бага дархан цаазат газар"-ын ажилтнууд, байгаль орчны байцаагчтай хамтран Цагаанхадны ойролцоох засмал замын зүүн талын уулын энгэрт цөөрмийн нүх гаргаж бэлдэн, усаар дүүргэсэн.

Компанийн ажиллагсад хиймэл уст цэг дээр тогтмол очиж зориудаар ус хийж бэлдсэнээр уг цооногноос хулан, хар сүүлт, зээр, бор гөрөөс гэх мэт амьтад ундаалж, өлдөж харангадахын аюулгүй болжээ.

### Хог хаягдлын ангилан боловсруулалт

Ухаа худаг уурхайн хүрээнд хогийг ангилж, ялгаж, дахиврын цехтээ боловсруулаад сандал, блок, хогийн сав зэрэг 20 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн хийдэг. Улмаар хог хаягдлын ангилан ялгалтыг улам бүр сайжруулах үүднээс бичгийн цаас, хуванцар сав, хаягдал зай зэргээ офисын хэмжээнд тусгайлан ангилж хаяж эхэлжээ. Мөн Ухаа худаг уурхайнхан ажиллаж, амьдарч буй орчноо цэвэр, цэмцгэр байлгахын төлөө жил бүрийн хавар, намар бүх нийтийн цэвэрлэгээнд сайн дураараа нэгддэг. Тайлант онд Хулсангийн шанд, Бумбан-Овоо, "Уурхайчин" хороолол болон Ухаа худаг уурхайн эргэн тойрны 28 га талбайг цэвэрлэж, 167 м3 хатуу хог хаягдлыг сумын хогийн цэгт хүргүүлсэн.




# Хөдөлмөрийн аюулгүй байдал

Ухаа Худаг төслийн хүрээнд олон улсын "ISO 14001:2015" "Байгаль орчны удирдлагын тогтолцоо" болон "OHSAS 18001:2008" "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ерөнхий шаардлага удирдлагын тогтолцоо" стандартуудын шаардлагын дагуу БОХАБЭА удирдлагын тогтолцоог нэвтрүүлэн ажилладаг.

## Онцлох ажил

- 2018 онд Монголдоо анх удаа Олон улсын стандартын дагуу Менежментийн нэгдсэн тогтолцоог үйл ажиллагаандаа нэвтрүүлэх ажлыг амжилттай хэрэгжүүллээ.
- Нийт ажиллагсад, гэрээт гүйцэтгэгч болон тэдгээрийн туслан гүйцэтгэгчдийн ажиллагсад 8.7 сая хүн цаг ажилласан тоон үзүүлэлттэй харьцуулахад хөдөлмөрийн чадвар түр алдалтын давтамжийн үзүүлэлт (ХЧТАД) 0.35 нэгжтэй гарсан нь өмнөх оныхоос 22 хувиар буурсан үзүүлэлт юм. Мөн нийт гэмтлийн давтамж 3.56 үзүүлэлттэй гарсан.
- Компанийн хэмжээнд хүлээсэн үүрэг хариуцлагын хүрээнд "Ослыг тэглэх алсын хараа" зорилтыг дэвшүүлэн ажиллаж байгаа бөгөөд ноцтой осол гэмтэл, хүний амь нас эрсэдсэн тохиолдол тайлант онд гараагүй болно.
- Нийт ажиллагсад, гэрээт гүйцэтгэгчид болон зочид гэх мэт нийт 15,492 хүнд хөдөлмөрийн аюулгүй байдлын тусгай материал танилцуулах сургалтыг хүргэж, үүнд нийт 62,549 хүн/цаг зарцуулсан байна.
- Уурхайн аваар, устгах төлөвлөгөө, цацрагийн аюулгүй ажиллагааны дотоод журам, хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж ОБЕГ, цөмийн болон цацрагийн хяналтаар хянуулан тус тус батлуулсан.
- 2018 оны зун тохиосон байгалийн гамшигт үзэгдэл болох үерийн аюулын үеэр уурхайн аврах багийнхан орон нутгийн онцгой байдал, гал унтраах ангитай хамтран нийт 6 иргэний амь насыг авран хамгаалсан.
- Олон жилийн дундажтай харьцуулахад их хэмжээний осол аваар гарч байгаа нүүрс тээврийн Тавантолгой-Гашуунсухайт авто зам дээр шаардлагатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлснээр Хугацаа алдсан гэмтлийн давтамж (LTIFR)-ийг 0.72 нэгжийн түвшинд хадгалж чадлаа.

## ОСОЛ ГЭМТЛИЙН ДАВТАМЖ (2012-2018)



## Менежментийн нэгдсэн тогтолцоо

Энержи Ресурс ХХК нь Олон улсын менежементийн нэгдсэн тогтолцоог үйл ажиллагаандаа нэвтрүүлээ.

Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015, Байгаль орчны менежментийн тогтолцоо ISO 14001:2015 ба Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцоо OHSAS 18001:2007 гэсэн Олон улсын 3 стандартаар Менежментийн нэгдсэн тогтолцоог нэвтрүүлэх бүтэн жилийн нөр их ажлын дүнд баталгаажуулалтын аудитыг Монгол-Францын хамтарсан, мэргэшсэн аудитурууд хийсэн.

Улмаар Ухаа худаг уурхайн хамт олон Монголын уул уурхайн салбарт төдийгүй Монголдоо анх удаа Олон улсын Менежментийн тогтолцоог амжилттай нэвтрүүлж, Францад төвтэй стандартчлалын Аfnор компаниас Баталгаажуулалтын гэрчилгээгээ гардан авсан юм. Энэхүү цогц тогтолцоог нэвтрүүлснээр компанийн хувьд бүтээмж, засаглал, бүтээгдэхүүний чанар гээд бүх талаас олон улсад хүлээн зөвшөөрөгдөөд зогсохгүй байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдлын стандартуудыг жигд мөрдөж, хариуцлагатай уул уурхай төлөвших гол ач холбогдолтой юм.

## МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧЛӨЛ



"0"



# 2018 оны амжилтууд


## Компанийн нийгмийн хариуцлагын олон улсын шагнал



Малайз улсад зохиогдсон 11 дэх удаагийн Global CSR Award буюу - Компанийн нийгмийн хариуцлагын олон улсын шалгаруулалтад дэлхийн 200 гаруй компанитай өрсөлдөж, орон нутагт хэрэгжүүлдэг төсөл хөтөлбөрүүдээрээ GOLD буюу Top шагналыг хүртлээ.

Компанийн нийгэм, орон нутагт хийж хэрэгжүүлдэг урт хугацааны төсөл хөтөлбөрүүд болон компанийн нийгмийн хариуцлагын ажлууд ийнхүү олон улсаас өндөр үнэлгээ авч чадсан юм.

## Оны онцлох Аж ахуйн нэгж



Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулж буй шилдэг ААН, бизнес эрхлэгчдийг шалгаруулан, шилдгийн шилдгээр өргөмжилдөг “Энтрепренер” ёслолын ажиллагааны үеэр Энержи Ресурс компанийг 2018 оны “Оны онцлох ААН”-ээр тодруулан мөнгөн Меркури шагналыг олгосон. Энержи Ресурс компанийн хувьд 2009 оноос хойш ес дэх жилдээ уг шалгаруулалтын ТОП 10 ААН-д багтсан амжилт үзүүлээд байна.

## Нүүрсний салбарын “ГранПри” шагнал

“Монгол Нүүрс Ассоциаци”-ийн дэргэдэх Хараат бус экспертүүдийн зөвлөл болон олон нийтийн цахим санал асуулгын дүнгээр нүүрсний салбарын оны “ТОП 5” компанийг тодруулсан. Ингэхдээ улсад төлж буй татвар, бүтээн байгуулалт, нийгмийн хариуцлага, орон нутгийн хамтын ажиллагаа гэх мэт нийгэм, эдийн засгийн үр өгөөжийг голлон анхаарчээ. Мөн АМГТГ-аас ирүүлсэн нүүрс олборлолтын мэдээ болон Авто тээврийн үндэсний төвөөс гаргасан нүүрс тээврийн гүйцэтгэлийн мэдээнүүдэд үндэслэн Энержи Ресурс компанийг нүүрсний салбарын “Шилдэгийн шилдэг” буюу ГранПри шагналын эзнээр тодруулжээ.



## Үндэсний чанарын шагнал

Засгийн газар, Стандартчилал хэмжил зүйн газар, МҮХАҮТ-аас World Quality Day буюу Дэлхийн чанарын өдрөөр Үндэсний чанарын шагналаар шагнагдсан.

## Нийгмийн даатгалын санг бүрдүүлэгч шилдэг ажил олгогч компани

Ажиллагсдынхаа нийгмийн баталгааг хангаж, хамгийн их шимтгэл төлөн, нийгмийн даатгалын сангийн орлогыг бүрдүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан шилдэг 15 ажил олгогчийн нэгээр нэрлэгдсэн.

## Усны менежментийн бүтээлч технологийн шагнал

ОУСК-иас "Усны менежментийн бүтээлч технологи"-ийн шагналыг олгосон. Энержи Ресурс компани нь усны менежментийн асуудалд онцгой анхаарал хандуулж, цэвэр усаар хомс говийн онцлогийг харгалзан үзэж, ус хангамжийн ухаалаг бөгөөд дэвшилтэт системийг нэвтрүүлэн ажилладаг. Энэ жилийн хувьд говьд буусан их үерээс тогтсон усыг технологийн аргаар цуглуулж, шаврыг тунгаах замаар үйлдвэрлэлд дахин ашиглаж эхэлсэн нь шинэлэг санаачлагаар нэрлэгдсэн юм.

## Эрүүл мэндийг дэмжигч шилдэг байгууллага



Өмнөговь аймаг 2018 оныг "Эрүүл мэндийг дэмжих жил" болгон зарласан. Энержи Ресурс компани уг аянд нэгдэж, нийт ажиллагсад ба иргэдийн эрүүл мэндийг дэмжих, эрүүл амьдралын хэв маягт уриалах, шаардлагатай орчныг бүрдүүлэх чиглэлд 3 жилийн төлөвлөгөөтэй, шат дараалсан алхмуудтай, томоохон хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Энэхүү санаачилга, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг үнэлэн Өмнөговь аймгаас "Эрүүл мэндийг дэмжигч шилдэг байгууллага"-аар шалгаруулсан.

Цэций хороолол,  
Цогтэций сум,  
Өмнөговь аймаг

Хаяг: Централ тауэр, 16 давхар  
Сүхбаатар дүүрэг  
Улаанбаатар хот 14200  
Монгол улс

Утас: +(976) 7012-2279, 7013-2279  
Факс: +(976) 11-322279  
Цахим шуудан: [contact@mmc.mn](mailto:contact@mmc.mn)  
Цахим хаяг: [www.energyresources.mn](http://www.energyresources.mn)

Ухаа Худаг, Уурхайчдын хотхон  
Ухаа Худаг, Цогтэций сум  
Өмнөговь аймаг 46040  
Монгол улс  
Утас: +(976) 7712-2304